



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/147

Чөлөөт хот

Угийн бичиг хөтлөх
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан "Угийн бичиг хөтлөх журам"-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Өрх бүрт гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, удам угсааг нь мэдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд нийт өрхөөр угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Батлагдсан журмын дагуу нийт өрхийг угийн бичиг хөтлөх арга зүйгээр хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Б.Энх- Эрдэнэ/-т, мөн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тооцож ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар /С.Мөнхцэцэг/т, тус тус үүрэг болгосугай.

3. Харьяалах нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА